

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/05-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040      Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036      Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Одсүрэн Утас: 7036-2442      Цахим хаяг: odsurent@audit.gov.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БОАЖГ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын газар
<b>БОАЖС</b>	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын яам
<b>БОХНСАХ</b>	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.24 № СЭА-2022/05-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,939,933.00</b>	<b>107,937,422.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>20,617,100.00</b>	<b>80,000,000.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>20,617,100.00</b>	<b>80,000,000.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	20,617,100.00	80,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>26,322,833.00</b>	<b>27,937,422.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,500,000.00	1,500,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>24,822,833.00</b>	<b>26,437,422.00</b>
35410	Бичиг хэргийн материал	2,598,500.00	2,600,050.00
35420	Аж ахуйн материал	5,731,900.00	462,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	938,800.00
35440	Түлш, шатах тослох материал	1,476,000.00	3,836,139.00
35470	Бусад хангамжийн материал	15,016,433.00	18,600,433.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>124,755,322.95</b>	<b>175,926,014.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>124,755,322.95</b>	<b>175,926,014.99</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>124,367,406.22</b>	<b>110,920,498.22</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,838,740.00	5,838,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,668,211.44)	(2,502,317.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	107,000,000.00	112,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,958,333.53)	(52,743,750.31)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	55,939,200.00	50,690,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,567,641.31)	(28,623,622.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,719,323.00	19,201,070.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,689,303.98)	(9,745,446.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,600,300.00	21,600,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,846,666.52)	(5,745,075.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>387,916.73</b>	<b>65,005,516.77</b>
39301	Программ хангамж	1,285,000.00	65,147,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,097,083.27)	(342,083.23)
39303	Бусад биет бус хөрөнгө	200,000.00	200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>171,695,255.95</b>	<b>283,863,436.99</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,617,100.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,617,100.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>20,617,100.00</b>	-
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>20,617,100.00</b>	-
41361	Байгууллагад төлөх өглөг	20,617,100.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>151,078,155.95</b>	<b>283,863,436.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>151,078,155.95</b>	<b>283,863,436.99</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	121,834,119.85	121,834,119.85
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>27,858,812.98</b>	<b>160,644,094.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(553,924.06)	27,858,812.98
51220	Тайлант үеийн үр дүн	28,412,737.04	132,785,281.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,385,223.12	1,385,223.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>171,695,255.95</b>	<b>283,863,436.99</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,267,024,620.00</b>	<b>1,305,429,251.10</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,139,750.00</b>	<b>1,064,785.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>21,139,750.00</b>	<b>1,064,785.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	20,700,000.00	480,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	439,750.00	584,785.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,245,884,870.00</b>	<b>1,304,364,466.10</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,775,000.00</b>	<b>81,500,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,238,109,870.00</b>	<b>1,222,864,466.10</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,238,109,870.00	1,222,864,466.10
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,134,990,582.96</b>	<b>1,163,689,573.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,134,990,582.96</b>	<b>1,163,689,573.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,092,966,846.96</b>	<b>1,143,077,833.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>515,394,417.00</b>	<b>549,529,167.46</b>
210101	Үндсэн цалин	411,318,868.00	382,052,287.16
210102	Нэмэгдэл	69,877,818.00	105,732,829.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,685,006.00	22,989,485.44
210104	Урамшуулал	14,512,725.00	38,754,565.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,016,274.00</b>	<b>71,051,977.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,852,699.00	49,842,119.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,153,257.00	5,533,754.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,122,606.00	4,410,201.87
210204	Ажилгүйдлийн даатгал	989,793.00	1,024,172.30
210205	Эрүүл мэндийн даатгал	9,897,919.00	10,241,729.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,295,400.00</b>	<b>1,935,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	360,000.00	0.00
210304	Байрны түрээс	1,935,400.00	1,935,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,343,055.00</b>	<b>28,573,191.00</b>
210401	Бичиг хэрэг	3,593,960.00	2,688,250.00
210402	Тээвэр, шатахуун	21,562,000.00	17,650,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,297,720.00	1,246,491.00
210404	Ном, хэвлэл	51,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,838,375.00	1,244,950.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,683,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,000,000.00</b>	<b>490,000.00</b>
210604	Урсгал засвар	36,000,000.00	490,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,783,900.00</b>	<b>4,085,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,783,900.00	4,085,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,222,528.00</b>	<b>9,826,430.00</b>

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	211,230.00	320,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,000.00	170,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	9,140,500.00
210807	Газрын төлбөр	71,298.00	140,280.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>430,411,272.96</b>	<b>477,586,166.94</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	402,968,177.00	439,888,656.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,303,095.96	37,697,510.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,023,736.00</b>	<b>20,611,740.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,023,736.00</b>	<b>20,611,740.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,997,000.00	9,719,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,026,736.00	10,892,740.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>132,034,037.04</b>	<b>141,739,678.06</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>103,621,300.00</b>	<b>8,954,397.02</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	754,397.02
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	103,621,300.00	8,200,000.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>28,412,737.04</b>	<b>132,785,281.04</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	(553,924.06)	122,665,418.91
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	(553,924.06)	122,665,418.91
9	Тайлант үеийн үр дүн	-	-	28,412,737.04	28,412,737.04
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	27,858,812.98	151,078,155.95
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	27,858,812.98	151,078,155.95
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	27,858,812.98	151,078,155.95
19	Тайлант үеийн үр дүн	-	-	132,785,281.04	132,785,281.04
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,245,884,870.00</b>	<b>1,304,364,466.10</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,245,884,870.00</b>	<b>1,304,364,466.10</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,775,000.00</b>	<b>81,500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,775,000.00	81,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,238,109,870.00</b>	<b>1,222,864,466.10</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,238,109,870.00	1,222,864,466.10
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,224,826,470.00</b>	<b>1,215,221,866.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,224,826,470.00</b>	<b>1,215,221,866.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,182,802,734.00</b>	<b>1,113,564,126.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>515,394,417.00</b>	<b>549,529,165.46</b>
210101	Үндсэн цалин	398,539,337.06	382,052,285.16
210102	Нэмэгдэл	82,657,348.94	105,732,829.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,685,006.00	22,989,485.44
210104	Урамшуулал	14,512,725.00	38,754,565.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,016,274.00</b>	<b>71,051,979.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,852,699.00	49,842,119.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,153,257.00	5,533,754.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,156,019.00	4,410,203.87
210204	Ажилгүйдлийн даатгал	956,380.00	1,024,172.30
210205	Эрүүл мэндийн даатгал	9,897,919.00	10,241,729.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,295,400.00</b>	<b>1,935,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	360,000.00	-
210304	Байрны түрээс	1,935,400.00	1,935,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,405,095.00</b>	<b>14,046,341.00</b>
210401	Бичиг хэрэг	2,498,100.00	2,128,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,800,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,297,720.00	1,332,891.00
210404	Ном, хэвлэл	152,700.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	656,575.00	525,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>1,428,800.00</b>
210604	Урсгал засвар	-	1,428,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,400.00</b>	<b>2,417,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,400.00	2,417,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,222,528.00</b>	<b>9,826,430.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	211,230.00	320,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,000.00	170,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	9,140,500.00
210807	Газрын төлбөр	71,298.00	140,280.00

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	571,468,620.00	463,328,510.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	571,328,620.00	463,328,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,023,736.00	101,657,740.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,023,736.00	21,657,740.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,997,000.00	9,765,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,026,736.00	10,892,740.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	80,000,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	80,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,058,400.00	89,142,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	21,058,400.00	89,142,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,058,400.00	89,142,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,058,400.00	89,142,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,058,400.00	89,142,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,058,400.00)	(89,142,600.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,282,739,800.00	1,222,864,466.10	59,875,333.90	95.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,282,739,800.00	1,222,864,466.10	59,875,333.90	95.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,675,500.00	1,202,206,726.10	56,468,773.90	95.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	576,747,700.00	549,529,165.46	27,218,534.54	95.28
210101	Үндсэн цалин	436,699,400.00	382,052,285.16	54,647,114.84	87.49
210102	Нэмэгдэл	73,652,400.00	105,732,829.86	(32,080,429.86)	143.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,568,000.00	22,989,485.44	6,578,514.56	77.75
210104	Урамшуулал	36,827,900.00	38,754,565.00	(1,926,665.00)	105.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,548,400.00	71,051,979.64	8,496,420.36	89.32
210201	Тэтгэврийн даатгал	55,978,500.00	49,842,119.19	6,136,380.81	89.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,892,500.00	5,533,754.90	358,745.10	93.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,714,000.00	4,410,203.87	303,796.13	93.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178,400.00	1,024,172.30	154,227.70	86.91
210205	Эрүүл мэндийн даатгал	11,785,000.00	10,241,729.38	1,543,270.62	86.90

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,935,400.00</b>	<b>1,935,400.00</b>	-	<b>100.00</b>
210304	Байрны түрээс	1,935,400.00	1,935,400.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,061,100.00</b>	<b>14,046,341.00</b>	<b>14,759.00</b>	<b>99.90</b>
210401	Бичиг хэрэг	2,031,100.00	2,128,400.00	(97,300.00)	104.79
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,000.00	1,332,891.00	(84,891.00)	106.80
210404	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	722,000.00	525,050.00	196,950.00	72.72
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,428,800.00</b>	<b>1,428,800.00</b>	-	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	1,428,800.00	1,428,800.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,428,100.00</b>	<b>2,417,500.00</b>	<b>10,600.00</b>	<b>99.56</b>
210702	Дотоод албан томилолт	2,428,100.00	2,417,500.00	10,600.00	99.56
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,926,000.00</b>	<b>9,826,430.00</b>	<b>99,570.00</b>	<b>99.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	320,600.00	320,550.00	50.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,100.00	170,100.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,239,100.00	9,140,500.00	98,600.00	98.93
210807	Газрын төлбөр	141,200.00	140,280.00	920.00	99.35
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>572,600,000.00</b>	<b>551,971,110.00</b>	<b>20,628,890.00</b>	<b>96.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	572,600,000.00	551,971,110.00	20,628,890.00	96.40
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,064,300.00</b>	<b>20,657,740.00</b>	<b>3,406,560.00</b>	<b>85.84</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,064,300.00</b>	<b>20,657,740.00</b>	<b>3,406,560.00</b>	<b>85.84</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	9,765,000.00	235,000.00	97.65
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,064,300.00	10,892,740.00	3,171,560.00	77.45
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,282,739,800.00</b>	<b>1,222,864,466.10</b>	<b>59,875,333.90</b>	<b>95.33</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,282,739,800.00</b>	<b>1,222,864,466.10</b>	<b>59,875,333.90</b>	<b>95.33</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,282,739,800.00	1,222,864,466.10	59,875,333.90	95.33
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>117.00</b>	<b>109.00</b>	<b>8.00</b>	<b>93.16</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>58.00</b>	<b>54.00</b>	<b>4.00</b>	<b>93.10</b>

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	51.00	4.00	92.73
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>58.00</b>	<b>54.00</b>	<b>4.00</b>	<b>93.10</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	53.00	50.00	3.00	94.34
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	4.00	1.00	80.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,500,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>81,500,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>500,000.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,000,000.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	80,000,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>81,500,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>81,500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,000,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /цаашид Байгаль орчин, аялал жуулчлалын газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, НДШ-ийн тайланг нөхөн залруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь “Өнөө болон ирээдүй үеийнхний төлөө байгальд ээлтэй хандлага, дадлыг олон нийтэд төлөвшүүлэн, байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтайгаар зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх замаар экосистемийн байгалийн унаган төрх, нүүдлийн соёлыг хадгалсан ногоон бүс нутаг болно” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны зорилт, чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах,
- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах,
- Байгаль орчныг хамгаалах ажилд иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах,

- Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, улсын захиалга, даалгаварт ажлын хэрэгжилтийг хангуулах,
- Ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг хамгаалах, түүнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- 3 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц зохион байгуулалтын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Тайлант жилийн хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал

дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,238,611.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,386,1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,670.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 112,168.2 мянган төгрөгөөр буюу 65.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	20,617.1	80,000.0	59,382.9
Бараа материал	26,322.8	27,937.4	1,614.6
Үндсэн хөрөнгө	124,755.3	175,926.0	51,170.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>171,695.3</b>	<b>283,863.4</b>	<b>112,168.2</b>
Өр төлбөр	20,617.1	-	(20,617.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	151,078.2	283,863.4	132,785.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>171,695.3</b>	<b>283,863.4</b>	<b>112,168.2</b>

Авлагын дансны үлдэгдэл 80,000.0 мянган төгрөг болж 59,382.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БОАЖС-ын 2021 оны А/27 дугаар тушаалаар “Хот суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох” ажлын урьдчилгаа санхүүжилт 80,000.0 мянган төгрөгийг 12 дугаар сарын 30-ны өдөр олгосноос татан төвлөрүүлж авлагаар

бүртгэсэн болон 2020 онд БОХНСАХ-ний зардлаар гүйцэтгэж байгаад Ковид-19 цар тахлын улмаас зогссон ажлуудын / Ойн хүрэм ХХК-ий ойжуулалтын ажлын үлдэгдэл санхүүжилт 15,617.1 мянган төгрөг, БААТУДС ХХК-ий Сүхбаатар сум орчмын аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл 5,000.0 мянган төгрөг/ хэрэгжилтийг хангуулан авлагыг барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд 27,937.4 мянган төгрөг болж 1,614.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь түлш, шатах тослох материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 275,628.3 мянган төгрөг болж 58,045.7 мянган төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас суудлын автомашин, гарал үүсэл, эрхийн бичгийг цахим болгох программ хангамж зэрэг 89,142.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ОНӨГ-аас 19,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгийн данснаас хасах зөвшөөрөл олгосон, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 122 дугаар тогтоолын дагуу 12,096.9 мянган төгрөгийн автомашиныг акталж данснаас хассан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь оны эхний үлдэгдэл 20,617.1 мянган төгрөг буюу дутуу хэрэгжсэн ажлын санхүүжилтийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 283,863.4 мянган төгрөг болж 132,785.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 38,404.6 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн нь дээд шатны төсвийн захирагчаас шилжүүлсэн нэмэлт төсвийн орлогоос голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 65,967.9 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардал 40,170.4 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 8,645.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 47,174.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 10,394.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, урсгал засварын зардал 35,510.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэвэр тэтгэмж 21,412.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 94,666.9 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,619,929.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Гэвч төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал үйл ажиллагааны зардлыг 110,174.0 мянган төгрөг, байгаль хамгаалах зардлыг 227,016.0 мянган төгрөгөөр нийт 337,190.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж байгаль хамгаалах зардлыг 572,600.0 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 710,139.8 мянган төгрөг, нийт **1,282,739.8** мянган төгрөгөөр тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагаанд **1,222,864.5** мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,222,864.5 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 27,218.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 8,496.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 20,628.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 3,406.6 мянган төгрөгөөр, бусад зардлыг 124.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд БОАЖЯ-аас 81,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/37 дугаар захирамжаар албан хаагчдыг шагнаж урамшуулахад зориулж 500.0 мянган төгрөг зэрэг нийт 81,500.0 мянган төгрөг төвлөрснөөс 1,500.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж үлдэгдэл 80,000.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** БОАЖС, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2021 оны А/27 дугаар тушаалаар “Хот суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох” ажлын урьдчилгаа санхүүжилтэд зориулж тус газрын нэмэлт санхүүжилтийн

дансанд 80,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 12 дугаар сарын 30-ны өдөр шилжүүлсэн байна.

Энэ нь төсвийг төсвийн жилийн хугацаанд багтаан зарцуулах цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэж төлөвлөсөн ажлыг тайлант онд багтаан зохион байгуулж амжилгүйгээр 80,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн татан төвлөрүүлж авлага үүсгэн тайлагнасан байна. Цаашид тухайн төсвийн жилд багтаан хэрэгжүүлэх боломжтой хугацаанд нь тооцож, санхүүжилтийг шийдвэрлэж байх нь зүйтэй юм.

**3.7.2** Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ**”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Түшиг сумын байгаль хамгаалагч Ч.Чойсүрэнжавын Материал техник хангамжийн удирдах газарт ажиллаж байсан 7 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор БОАЖГ-ын даргын 2021 оны Б/34 дүгээр тушаалаар 10,892.7 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Материал техник хангамжийн удирдах газар нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

**3.7.3** БОАЖС болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №21-16 тоот гэрээний хавсралтаар БОХНСАХ-ний зардлын эх үүсвэрээр 572,600.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх жагсаалтыг баталсан атал аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийхдээ гэрээнд заасан 5 төсөл, арга хэмжээг хасаж, шинээр 2 төсөл арга хэмжээг нэмж, дээрх гэрээгээр баталсан төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн байна.

Энэ нь БОАЖС-тай хамтран ажиллахаар байгуулсан гэрээний эрх ба үүргийг зөрчиж байгаа тул гэрээнд заасан төсөл арга хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд БОАЖС-тай харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулсны үндсэн дээр ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулах нь зүйтэй юм.

**3.7.4** БОАЖГ-аас БОХНСАХ-ний эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж, ИТХ-аар хэлэлцүүлэхдээ Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах

журам"-ын 3.1-3.4 дэх заалтуудад хамаарахгүй дараах арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- ITM үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх,
- Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан аппликейшныг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх,
- Ээж мод, Гонирын бумбаны арга хэмжээг зохион байгуулахад аймгийн "Аялал жуулчлалын холбоо"-нд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах,
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэрэгцээнд автомашин авах,

Энэ нь БОХНСАХ-нд зарцуулагдах төсвийг хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байгаа учир төсвийн жилд хэрэгжүүлэх БОХНСАХ-ний төсөл арга хэмжээг журамд заасан зориулалтаар төлөвлөж, батлуулж байх нь зүйтэй юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 1 мэдээлэл / *бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 1,2,5 саруудад* /-ийг 3 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны үйл ажиллагаанд 1,282,739.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,222,864.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.7 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	1,276.3	1	1,276.3	100
Албан шаардлага	3	14,836.5	3	14,836.5	100
Зөвлөмж	2	-	2	-	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>16,112.8</b>	<b>6</b>	<b>16,112.8</b>	<b>100</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 215,045.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн 85.3 мянган төгрөгийн худалдан авалт орж шивэгдсэн бол харилцагч байгууллагуудын дутуу шивсэн 16,148.3 мянган төгрөгийн ажил гүйлгээ байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч, данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **9,091.4** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,360.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 6,731.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгөгдлөө.

### 4.1 Албан шаардлага

4.1.1 Тээвэр шатахууны батлагдсан төсвийн хэмнэлт 2,360.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлэлгүйгээр шатахуун нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “...Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд .... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан

төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны үлдэгдлийг 2022 оны хэрэглээнд суутган тооцож, хэмнэлтийг 2022 оны төсвөөс тооцож, татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийн дагуу нэр төрлөөр бус бөөн дүнгээр 3,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ цахим системд шивэгдсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх

##### 2. НДШ-ийн төлөлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант жилийн 3, 8 дугаар саруудад сумдаас цагийн тооцоо ирүүлээгүй шалтгаанаар 3 албан хаагчийн 3,131.3 мянган төгрөгийн цалинг дараа сард нь нөхөн олгож, тухайн саруудын НДШ төлөлтийг тасалдуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан

нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ". гэсэн заалтыг зөрчсөн ба Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх 3 албан хаагчийн тасарсан саруудын НДШ төлөлтийг залруулж, тасарсан хугацааг нөхөн тооцуулах арга хэмжээг авч, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3	9,091.4					1	2,360.1	2	6,731.3
	<b>Нийт</b>	<b>3</b>	<b>9,091.4</b>					<b>1</b>	<b>2,360.1</b>	<b>2</b>	<b>6,731.3</b>